

ТЭТГЭМЖИЙН ТОГТООЛТ, ОЛГОЛТЫН БАЙЦААГЧ Ж.ОДМААГИЙН
2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2024.12.05.

2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр хүүхдээ асрах чөлөөний хугацаа дуусгавар болж тэтгэмжийн тогтоолт, олголтын байцаагч мэргэжилтэн албан тушаалд томилогдон ажиллах хугацаандаа доорх ажил үүргийг гүйцэтгэн ажилласан байна.

Ажиллах хугацаандаа Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найрууллага батлан 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болсон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дагуу мэдээллийн бааз бүрэн шинэчлэгдэн шинэчилсэн системд даатгуулагчийн мэдээллийг бүрэн зөв оруулж,цаг хугацаанд нь олгож байгаа эсэхэд хяналт тавин нийгмийн даатгалын сангаас олгож буй хөдөлмөрийн чадвар алдсаны, жирэмсэн, асаржсаны, оршуулгын тэтгэмж, ҮОМШӨ-ний тэтгэмжийн тогтоолт, олголт, ҮОМШӨ даатгалын сангаас олгох нөхөн сэргээх амралт сувилалын зардлыг олгож ажилласан байна. Үүнд:

- Тэтгэмжийн даатгалын сангаас 300 эхэд 848 030 408 төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж
- Тэтгэмжийн даатгалын сангаас 1500 даатгуулагчдад 1 900 880 төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- ҮОМШӨ-ний хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмжийг 30 даатгуулагчид 60 776,699 төгрөгийн

Үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний сувилалын зардалын 8 даатгуулагчид 2 086 000 төгрөгийн тэтгэмжийг хуулийн хугацаанд бодолт хийж, сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэнд олголтын тайланг хуваарийн дагуу бэлтгэн өгч ажиллалаа.

- 2024 онд тогтоож олгосон тэтгэмж авагчдын тоогоор харуулбал:

	Тэтгэмжийн төрөл	Даатгуулагчийн тоо	Олгосон тэтгэмжийн хэмжээ
1	ХЧТА	1500	1.900,8 сая төгрөг
2	ЖА	300	848.030 сая төгрөг

3	ҮОМШӨ		30	60.776 сая төгрөг
4	ОРШУУЛГА		150	300.0 сая төгрөг
5	ҮОМШӨ сангаас сэргээх зардалд	даатгалын олгох нөхөн амралт сувилалын	8	2.1 сая төгрөг

2 дугаар улиралд системийн шинэ программын алдаанаас үүдэлтэй оршуулгын тэтгэмж авсан иргэдийн авлага хаалт уншигдахгүй байгааг шалгаж нийт 150 гаруй иргэний мөнгө авагчаар оршуулгын тэтгэмж шүүж, 52 оршуулгын тэтгэмжийг сикос програмд эх материалаас нөхөн оруулсан болно.

Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь биелүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна. Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэрийг иргэд даатгуулагчдад сурталчилан CALL PRO 72001289 утсанд 2024.10.14-2024.10.18, 2024.11.13, 2024.11.21, 2024.12.02-ны өдрүүдэд холбогдсон 600 гаруй иргэд, даатгуулагч, ААНБ-уудад мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа.

Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 1111 төвд ажил олгогч, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн 9 өргөдөл албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллалаа.

ТЭТГЭМЖИЙН ТОГТООЛТ,

ОЛГОЛТЫН БАЙЦААГЧ:



Ж.ОДМАА